

## ТАНИЛЦУУЛГА

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар Боловсрол, шинжлэх ухааны яам болон түүний харьяа байгууллагуудад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

2023 оны 12 дугаар сарын 28

Улаанбаатар хот

Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам өссөн дүнгээр гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Боловсрол, шинжлэх ухааны яам (цаашид “БШУЯ” гэх) болон сайдад ажлаа шууд хариуцан тайлагнадаг харьяа байгууллагуудад 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар нийт 3568 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлсэн байна.



Иргэдээс Боловсрол, шинжлэх ухааны яам болон албан тушаалтанд хандан 2023 оны 4 дүгээр улиралд нийт 3568 өргөдөл, гомдол ирүүлснээс 19,5% нь цахимаар, 45,5% нь бичгээр, 35% нь биечлэн уулзсан байна.

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилж үзвэл хүсэлт 1429 буюу 40,0%, санал 246 буюу 6,9%, гомдол 1893 буюу 53,1% байна.



Хүснэгт. Ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга.

№	Тоо	Хувь	Өргөдөл гомдлын агуулга
1	665	18,6	Хууль эрх зүй, бодлого, үйл ажиллагааны чиглэлээр
2	932	26,1	Лавлагаа, бүртгэлийн чиглэлээр
3	770	21,6	Оюутны зээл, тусламж, тэтгэлгийн чиглэлээр
4	595	16,7	Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийн чиглэлээр
5	606	17	Санхүүжилт, нийгмийн баталгааны чиглэлээр

### **Шийдвэрлэлт:**

2023 оны 4 дүгээр улиралд ирүүлсэн 3568 өргөдөл, санал, хүсэлтийн 3548 буюу 99,0 хувийг шийдвэрлэсэн дүнтэй байна. Шийдвэрлэгдээгүй 20 өргөдөл хугацаандаа судлагдаж байна.

### **Цаашид:**

- Эрхэлсэн асуудлын чиглэлээр боловсруулах хууль тогтоомж, дүрэм, журам болон яамнаас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд агуулагдсан санал, санаачилгыг тусгахад анхаарна.
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан ажиллана.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ